


2019 оны 12 дугаар сарын 27, Варшав хот

Саналын дугаар: JUD-MNG/363/2019

[www.legislationline.org](http://www.legislationline.org)



## **МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН САНАЛ**

**Хуулийн албан бус Англи орчуулганд үндэслэн гаргав**

*Энэхүү АИХЭГ-ын Саналыг*

*Олон улсын хүний эрхийн хуулийн эксперт хатагтай Алис Томас бэлтгэн гаргасан  
бөгөөд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Сассекс Их Сургуулийн  
Проф.Ричард Воглер хувь нэмэр оруулсан болно.*

ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар

Ulica Miodowa 10 PL-00-251 Warsaw утас. +48 22 520 06 00 факс. +48 22 520 0605

## **ГАРЧИГ**

|                                                                                                                                                              |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. Шүүх хуралдаан дахь иргэдийн оролцооны талаарх олон улсын стандарт болон улсын жишгүүд .....                                                              | 5  |
| 2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаарх Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж ..... | 9  |
| 3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулалт болон шүүх бүрэлдэхүүн .....                                                                            | 11 |
| 4. Иргэдийн төлөөлөгчийн эрх .....                                                                                                                           | 15 |
| 5. Иргэдийн төлөөлөгчийн үүрэг, татгалзан гаргах болон хариуцлага хүлээлгэх ..                                                                               | 18 |
| 6. Эцсийн дүгнэлт .....                                                                                                                                      | 22 |

**Хавсралт:** Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

**I. ТАНИЛЦУУЛГА**

1. 2019 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (цаашид “АИХЭГ” гэнэ)-т Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль (цаашид “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хууль” гэнэ) болон шүүхийн тухай өөр дөрвөн хуульд хуулийн дүгнэлт гаргуулахаар хүсэлт илгээсэн болно.
2. Хүсэлт гаргасан талтай ярилцсаны үр дүнд хуулийн дүгнэлтийг гурав хувааж гаргахаар болсон. Энэхүү хуулийн дүгнэлт зөвхөн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуульд хийсэн хэдий ч Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Шүүхийн захиргааны тухай хуульд хийсэн дүгнэлт болон Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд<sup>1</sup> хийсэн дүгнэлтийн хамт танилцвал зохимжтой.
3. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтэд АИХЭГ 2019 оны 9 дүгээр сарын 11-ы өдөр хариу илгээж Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хууль болон бусад шүүхийн тухай хуулиуд ЕАБХАБ-ын болон олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн эсэхэд хуулийн дүгнэлт боловсруулахаа мэдэгдсэн.
4. Энэхүү дүгнэлт дээрх хүсэлтийн дагуу хийгдсэн болно. АИХЭГ нь ЕАБХАБ-ын гишүүн улсуудад ЕАБХАБ-ын хүний эрхийн үүргийг<sup>2</sup> хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүргийнхээ хүрээнд энэхүү үнэлгээг хийлээ.

**II. ДҮГНЭЛТИЙН ЦАР ХҮРЭЭ**

5. Энэхүү дүгнэлт зөвхөн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд хийсэн бөгөөд шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй холбоотой Монгол Улсын бусад институцийн болоод хууль, эрх зүйн бичиг баримтуудыг бүхэлд нь хамаарахгүй.
6. Дүгнэлт тулгамдаж буй асуудлууд болон сайжруулах шаардлагатай заалтуудыг тодорхойлсон. Тодруулбал, хуулийн сайн заалтуудад анхаарахаас илүү сайжруулах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай заалтууд руу анхаарлаа түлхүү хандуулсан болно. Дүгнэлтэд оруулсан зөвлөмжүүд нь ЕАБХАБ-ын үүрэг, олон улсын стандарт болоод олон улсын болон дотоодын сайн туршлага дээр үндэслэсэн болно.
7. Мөн түүнчлэн, Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг устгах конвенци<sup>3</sup> (цаашид “CEDAW” гэнэ) болон ЕАБХАБ-ын үйл ажиллагаанд

<sup>1</sup> Монгол Улсын хууль болон хуулийн төсөлд өгсөн дүгэлтүүдийг эндээс харах боломжтой: <<https://www.legislationline.org/odihr-documents/page/legal-reviews/country/60/Mongolia/show>>.

<sup>2</sup> OSCE Decision No. 7/08 Further Strengthening the Rule of Law in the OSCE Area харна уу (2008), зүйл 4, Сайд нарын зөвлөл “оролцогч улсуудыг эрх зүйт ёсыг бэхжүүлэх, мэдээлэл солилцох, сайн туршлага хуваалцах, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах, түүний захиргааг үр дүнтэй хэрэгжүүлэх, шүүхээр үйлчлүүлэх, шударга шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх, хариуцлагатай төр, төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн туслалцаа авах эрх, баривчлах байран дахь хүний эрхийг хүндэтгэх зэрэг асуудлуудыг хэрэгжүүлэхэд ЕАБХАБ болон түүний бүтцийн байгууллагуудын туслалцааг авахыг уриалж байна[...]”.

<sup>3</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг устгах конвенци (цаашид “CEDAW” гэнэ) Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 сарын 18-ны өдрийн 34/180 дугаар тогтоолоор батлагдав. Монгол Улс 1981 онд соёрхон баталсан.

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

жендэрийн тэгш байдлын хангах 2004 оны ЕАБХАБ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу тус хуулийн үр дүн эрэгтэй, эмэгтэй<sup>4</sup> хүмүүст хэрхэн нөлөөлөхөд дүн шинжилгээ хийхийг эрмэлзлээ.

8. Энэ дүгнэлтийг боловсруулахад Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуулийн албан бус Англи орчуулгыг ашигласан. Буруу орчуулгын улмаас ойлголтын зөрүү гарч болзошгүй. Энэ дүгнэлт мөн Англи хэлээр байгаа ба Англи хувилбар нь албан ёсных мөн.
9. Энэ дүгнэлтийг гаргаснаар АИХЭГ цаашид Монгол Улсын холбогдох хууль эсхүл хамаарал бүхий эрх зүйн баримт бичигт бичгэн болон аман зөвлөмж, санал гаргах эрхийг хязгаарлахгүй болно.

### **III. ТОЙМ**

10. ЕАБХАБ-ын гишүүн улсууд болон бусад улсын хуулийн адил шүүхийн захиргаанд иргэдийн оролцоог хангана гэдэг эерэг үзүүлэлт юм. Мөн тус хуульд заасны дагуу хуулийн зорилт нь шүүн таслах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлж, хяналт тавих зорилготой байна.
11. АИХЭГ нь тус заалтыг Монгол Улсын шүүхийн тогтолцоо болон процессийн эерэг үзүүлэлт гэж үзэж байгаа бөгөөд Монгол Улсын хууль тогтоогчид шүүхийн иргэдийн төлөөлөгч сонгон шалгаруулах ажиллагааг шударга, чадавхжуулах боломж олгосон, шүүн таслах ажиллагаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг хангалттай тодорхойлсон болохыг цохон тэмдэглэлээ.
12. Үүний зэрэгцээ, тус хууль өөр хэд хэдэн хуулиар зохицуулагдсан харилцаа байх ба энэ нь хуулийн давхцал, ойлголтын зөрүү үүсгэсэн зөрчилдөөнтэй заалтууд байна. Ямар тохиолдолд аль хуулийг дагаж, мөрдөх нь тодорхойлоогүй байхаас гадна ийм асуудлаас болоод хэд хэдэн гол асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна. Үүнд, иргэдийн төлөөлөгчийн үүрэг болон эрх мэдлийн хэмжээ, сонгон шалгаруулах процесс, иргэдийн төлөөлөгч татгалзан гарах болон гомдол гаргах ажиллагаа, буруу шийдвэрийн улмаас хүлээх хариуцлага болон бусад.
13. Тус хуульд шүүх хуралд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн тоог 1 байлгаж хязгаарлаж байгаа шалтгаан нь тодорхойгүй байна (lay judges буюу мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой бусад улсууд ихэвчлэн 2 эсхүл 3 мэргэжлийн бус шүүгчид суулгадаг байна). Мөн шүүх хуралдааны мэтгэлцээнд оролцох, санал өгөх эсхүл асуулт асууж, хэрэгт дүгнэлт гаргаж өгөх (дүгнэлтийг хуралдаан даргалаж буй шүүгч хүлээн авах эсхүл татгалзаж болно) нь тодорхойгүй байна. Эцэст нь тус хууль иргэдийн төлөөлөгчийн хангамж болон ажлын байрны баталгааг хангалттай хамгаалахгүй байна.
14. Иймд тус хуулийн зорилго болон үр дүнг сайжруулах зорилгоор ЕАБХАБ/АИХЭГ дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:
  - А. тус хуулийн заалтуудыг дахин нягтлах, тус хуулийн 2 дугаар зүйлд заасан бусад хуультай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг

<sup>4</sup> Догол мөр 32-ыг харна уу, No. 14/04, MC.DEC/14/04 (2004) шийдвэрээр батлагдсан [OSCE Action Plan for the Promotion of Gender Equality](#)

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

- шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хооронд зөрчилдөөнтэй заалт, ойлголтыг арилгах; [догол мөр 40]
- В. иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулж буй ажиллагааны нээлттэй болон шудрага байдлыг хангах, сонгон шалгаруулалтыг илүү дэлгэрэнгүй, тодорхой болгох; [догол мөр 52]
- С. шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн байр суурь болон чиг үүргийг тодорхой болгох ба хуралдаанд оролцож буй шүүгчдийн бүрэлдэхүүний тоотой адил байх эсхүл илүү байхаар хуульд нөмөлт өөрчлөлт оруулах; [догол мөр 56]
- Д. иргэдийн төлөөлөгчийн үүргийг хуульд илүү тодорхой болгож хэргийн шийдвэр гаргалтад оролцох эсхүл мэтгэлцээнд оролцох эсэхийг нарийвчлан заах; [догол мөр 69]
- Е. иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас татгалзан гарах нөхцөлийг тодорхой жагсааж, татгалзан гарах ёстой нөхцөл үүссэн тохиолдолд хэрхэх ёстойг болон эс үйлдэхүйд тооцох хариуцлагыг заах; [догол мөр 89]
- Ү. хуульд хүлээх хариуцлагын талаар бүтэн бүлэг нэмж оруулах, тус бүлэгт ямар ааш, зан гаргавал ямар хариуцлага хүлээхийг заах ба Эрүүлийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хүлээх хариуцлагыг тусгах. [догол мөр 95]

*Тус саналд **bold** хэлбэрээр оруулсан нэмэлт зөвлөмжүүд багтсан болно.*

#### **IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БОЛОН ЗӨВЛӨМЖ**

##### **1. Шүүх хуралдаан дахь иргэдийн оролцооны талаарх олон улсын стандарт болон улсын жишгүүд**

15. Хуулийн захиргаанд иргэдийн оролцоог шүүхийн үйл ажиллагаанд оролцуулж хангахыг зорьдог хэд хэдэн улс байдаг. Үүнд (АНУ, Их Британи, ОХУ, Испани, Гүрж зэрэг улсууд) шүүх хуралдааны шийдвэрийг жүгү (төлөөлөгчдийн шүүх) буюу иргэдийн төлөөлөгчдөөр гаргуулдаг бол (ХБНГУ, Хорват болон Япон зэрэг улсууд)<sup>5</sup> шүүх хуралдааныг мэргэжлийн болон мэргэжлийн бус шүүгч нарын бүрэлдэхүүнтэй явуулж холимог шүүхийн тогтолцоотой байдаг байна.
16. Шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгч оролцуулж байгаа шалтгаан нь улс тус бүрийн хооронд ялгаатай байдаг, зарим улс хариуцагч/шүүгдэгчийн үүргийг бэхжүүлэх зорилготой байдаг бол зарим нь шүүн таслах ажиллагааг явуулахдаа нээлттэй байх зарчмыг баримтлах, шүүх эрх мэдлийн хүрээнд авлигатай тэмцэж өрсөлдөхүйц чадварыг нэмэгдүүлэх, шүүхийн тогтолцоонд итгэл, дэмжлэг нэмэгдүүлэх болон хүнд суртлыг бууруулах зорилготой байдаг. Ихэнх тохиолдолд иргэдийн төлөөлөгч эсхүл мэргэжлийн бус шүүгчид мэргэжлийн шүүгчдээс илүү хараат бус байдаг бөгөөд тухайн улсын төрийн бодлого, нөлөөнд бага ордог. Мөн тэд төрийн эрх мэдэлд<sup>6</sup> хяналт тавих хүчин

<sup>5</sup> Sanja Kuntjak Ivkovic-ыг харна уу: *Ears of the Deaf: The Theory and Reality of Lay Judges in Mixed Tribunals*, Chicago-Kent Хуулийн дүгнэлт, 90-р хэсэг, 3 дахь хэвлэл (Төлөөлөгчдийн болон мэргэжлийн бус шүүгчийн оролцоо: АНУ-ын харах өнцөг ба Дэлхийн Трэнд), 2015 оны 6 сарын 6, хуудас. 1031.

<sup>6</sup> Toby S. Goldbach and Valerie P. Hans : *Juries, Lay Judges, and Trials* (2014) харна уу. Cornell Law Faculty Working Papers. Хуудас 122, хэсэг. 1.

зүйл болдог. Иргэдийн төлөөлөгчийг шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулснаар шүүхийн шийдвэрийг болон шүүх эрх мэдлийг бүхэлд нь хүчин төгөлдөржүүлж, хууль ёсны байдлыг хангадаг.<sup>7</sup> Мөн түүнчлэн, *lay judges* буюу мэргэжлийн бус шүүгчид шүүх хуралдааны мэтгэлцээнд болон нотлох баримт судлан, шинжлэх ажиллагаанд оролцохдоо өөрсдийн туршлага дээр тулгуурладаг, ингэснээр шүүхийн шийдвэрт тухайн нийгмийн нөхцөл байдлыг тусгуулж, ардчилсан оролцоог сайжруулж, “хуульд иргэдийн дуу хоолойг хүргэдэг”<sup>8</sup> байна. Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд биечлэн байснаар шүүгч ёс зүйн алдаа гаргах, шийдвэр гаргахдаа нэг талыг баримтлахаас сэргийлэхэд тус болохын сацуу шүүхийн шийдвэр үндэслэлтэй болон ил тод болж, шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртоно.<sup>9</sup>

17. Олон улсын түвшинд *lay judge* буюу мэргэжлийн бус шүүгчид тавигдсан стандарт тийм ч олон байдаггүй. НҮБ-ын Шүүх эрх мэдлийн бие даасан дайлыг хангах суурь зарчмууд мэргэжлийн шүүгчид рүү түлхүү анхаарсан байдаг ч удиртгал хэсэгтээ *lay judges* буюу мэргэжлийн бус шүүгчийн тогтолцоотой улсуудад мөн адил хамаарна гэж заасан байна.<sup>10</sup> Мөн НҮБ-ын Хүний эрхийн хороо зөвлөмжиндөө *lay judges* буюу мэргэжлийн бус шүүгчид мэргэжлийн шүүгчидтэй адил хараат бус байх болон бие даасан байх шаардлага тавигдах ёстойг тэмдэглэсэн байна.<sup>11</sup> Европын хүний эрхийн шүүх (цаашид “ЕХЭШ” гэнэ) үүнийг үлгэрчлэх дүрэмдээ тусгасан байдаг.<sup>12</sup>
18. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай европын конвенцийн 6 дугаар зүйлд заасны дагуу шүүн таслах ажиллагааны шудрага байх зарчимд үндэслэн шүүхийг байгуулахдаа хууль, журмыг дагаж мөрдөөгүй бол тус шүүх шүүн таслах ажиллагаа явуулах эрхгүй.<sup>13</sup> Хуулийн дагуу сонгогдоогүй *lay judges* буюу мэргэжлийн бус шүүгчид шүүх хуралдаанд оролцох болон тухайн жилд шүүх хуралдаанд оролцох хязгаар нь хэтэрсэн байсныг,<sup>14</sup> мөн холбогдох хууль хүчингүй болсон байтал шүүх хуралдаанд оролцооор байсан хэргүүд гарсанг Европын хүний эрхийн шүүх илрүүлсэн байна.<sup>15</sup>
19. *Lay judges* буюу мэргэжлийн бус шүүгч эсхүл холимог *tribunal* буюу шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй тусгай шүүхтэй улсууд хэмжээ, бүрэлдэхүүн, шалгуур,

<sup>7</sup> Өмнө нь 5-р зүүлт тайлбарт иш татсан, pp. 1037-1038.

<sup>8</sup> Өмнө нь 6-р зүүлт тайлбарт иш татсан

<sup>9</sup> Өмнө нь 5-р зүүлт тайлбарт иш татсан, хуудас. 1039.

<sup>10</sup> НҮБ-ын Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын талаарх *Суурь Зарчим*, НҮБ-ын Миланд 1985 оны 8 сарын 26-9 сарын 6 хооронд зохион байгуулагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон зөрчил үйлдэгчдийн эмчилгээ сэдэвт 7 дугаар Конгрессийн уулзалтаар батлагдсан ба Ерөнхий Ассеймблейн 1985 оны 11 сарын 29-ны дөрийн 40/32 дугаар тогтоолоор болон 1985 оны 12 сарын 13-ны өдрийн 40/146 дугаар тогтоолоор тус тус дэмжигдсэн.

<sup>11</sup> *Karttunen v Finland-ын маргааныг харна уу*, хэргийн дугаар. 387/1989, 1992 оны 10 сарын 23-ны өдрийн Хүний эрхийн хорооны үзэл баримтлал, догол мөр 7.2, мэргэжлийн бус шүүгч буюу *lay judges* Олон улсын иргэний болон улс төрийн эрхийн тухай конвенцийн 14-р зүйлийг зөрчсөнг Хүний эрхийн хороо тогтоосон, ийм хараат бус байдлын зарчмыг алдагдуулсан шүүх хуралдаан шударга эсхүл хараат бус байсан гэх хэлэх боломжгүй. Хүний эрхийн хорооны илрүүлсэн ижил төстэй хэргүүдийг харна уу, төлөөлөгчдийн шүүх *Rookmin Mulai, Lallman Mulai болон Bharatraj Mulai нар Guyana эсрэг*, хэргийн дугаар. 811/1998, 2004 оны 7 сарын 20-ны өдрийн Хүний эрхийн хорооны үзэл баримтлал, догол мөр 6.1-6.2. Мөн Сайд нарын хорооны МС.ДЕС/7/09-ыг харна уу, үүнд бүх гишүүн улсууд “бүх хуулийн, шүүх эрх мэдлийн, гүйцэтгэх эрх мэдлийн болон аюулгүй байдлын үйлчилгээ, цагдаа зэрэг байгууллагууд дахь жендэрийн тэгш байдлыг хангах зорилгыг хангахыг хичээж ажиллах”-ыг уриалав болон ЕАБХАБ-ын Москва дахь 1991 оны бичиг баримт дээр бүх гишүүн улс “шүүгчид шалгуурт нийцсэн байх, чадавхжуулсан болон ялгаварлан гадуурхахгүйн зарчмын дагуу сонгогдсон” байна (19.2)

<sup>12</sup> Европын хүний эрхийн шүүх, *Langborger v Sweden*, хэргийн дугаар 11179/84, 1989 оны 6 сарын 22 өдөр шийдвэрлэгдсэн, догол мөр 34-35. Мөн *Cooper v United Kingdom-ын хэргийг харна уу*, хэргийн дугаар. 48843/99, [GC] 2003.12.16 шийдвэр, догол мөр 123 (энэхүү шийдвэрт, дэлгэрэнгүй заавар болон энгийн гишүүдийн (мэргэжлийн бус шүүгч) сургалт өгч сургалтаар заналхийлэл, аюул тохиолдвол хэрхэх талаар орсон, эдгээр энгийн гишүүдийн бие даасан байдлын баталгааг хамгаалах оролдлого их байсан.

<sup>13</sup> Европын хүний эрхийн шүүх, *Posokhov v Russia маргаан*, хэргийн дугаар. 63486/00, 2003.3.4 шийдвэр, догол мөр 39-44.

<sup>14</sup> Өмнөх-д дурьдагдсан, догол мөр 39-44.

<sup>15</sup> Европын хүний эрхийн шүүх, *Pandjikidze v Georgia*, хэргийн дугаар. 30323/02, 2009.10.21 шийдвэр, догол мөр 104-111.

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

хэрэг маргааны төрөл болон тус шүүхээр шийдвэрлэх маргаан зэргийг өөр хоорондоо ялгаатай байдлаар хуульчилсан байна.<sup>16</sup>

20. Харин нийтлэг зүйл заалтын хувьд lay judge буюу мэргэжлийн бус шүүгч “дундаж иргэн” байна, тухайн улсын иргэн байна,<sup>17</sup> тодорхой насны хязгаар заах<sup>18</sup> бөгөөд тухайн улсын хэлээр ярьдаг, ойлгодог байх ёстой.<sup>19</sup> ХБНГУ болон Норвеги зэрэг улсуудад lay judges буюу мэргэжлийн бус шүүгчид шүүгч, прокурор, өмгөөлөгч болон цагдаагийн адил хуульч мэргэжилтэй байж болдоггүй.<sup>20</sup> Харин ХБНГУ болон Хорват улсууд lay judges буюу мэргэжлийн бус шүүгчийг мэргэжлийн шүүгчид байдаггүй хуулийн-бус мэдлэг, чадвартай байхыг шаарддаг, жишээлбэл, насанд хүрээгүй хүнтэй холбоотой шүүх хуралдаанд оролцож байгаа бол боловсролын салбарт сурган хүмүүсүүлэх мэргэжилтэй байх эсхүл туршлагатай эцэг, эх байхыг шаарддаг.<sup>21</sup> Өөр тусгай мэргэжил, мэдлэг шаардагдсан салбарт мөн адил үйлчилнэ.
21. Lay judge буюу мэргэжлийн бус шүүгч сонгон шалгаруулах нь улс болгонд өөр өөр байдаг. Ихэвчлэн тус шүүхийн Ерөнхий шүүгч, хотын иргэдийн төлөөлөгчдийн хурал эсхүл шүүхийн тусгай комисс байгуулан нэр дэвшсэн эсхүл түүвэрээр сонгогдсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулдаг.<sup>22</sup> Сонгогдсон lay judge буюу мэргэжлийн бус шүүгч тодорхой хугацаагаар томилогдоно.<sup>23</sup>
22. Lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй ихэнх улс эрүүгийн хэрэг дээр lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийг оролцуулдаг,<sup>24</sup> ба зарим улс эрүү болон иргэний хэрэг аль, алинд нь оролцуулдаг байна.<sup>25</sup> Зарим улс lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийг худалдааны,<sup>26</sup> насанд хүрээгүй хүний,<sup>27</sup> зэрэг төрөлжсөн хэргүүдэд оролцуулдаг байна. Зарим улс lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийг зөвхөн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд оролцуулдаг бол зарим нь зөвхөн давж заалдах шатны шүүхийн хэрэг эсхүл ноцтой хэрэг, зөрчил дээр оролцуулдаг байна. Мөн холимог tribunal буюу шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй тусгай шүүхтэй улс бүр хоорондоо өөр өөр шүүгчдийн бүрэлдэхүүн, тоотой байдаг: ХБНГУ болон Хорват улсад анхан шатны шүүхэд 1 мэргэжлийн шүүгч болон 2 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй байдаг,<sup>28</sup> Финлянд болон Швед улсад 1 мэргэжлийн шүүгч, 3 lay judge буюу мэргэжлийн

<sup>16</sup> Өмнө нь 5-р зүүлт тайлбарт иш татсан, хуудас. 1031.

<sup>17</sup> ХБНГУ-ын Шүүхийн 1975 оны Үндсэн хууль, 31 хэсгийг харна уу, хамгийн сүүлд 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон.

<sup>18</sup> Хорват улсад, доод тал нь 18 насанд хүрсэн байна, 2005 оны Хорват улсын шүүхийн тухай хууль, болон өмнөх зүүлт тайлбарт дурьдагдсан. ХБНГУ-д зөвшөөрөгддөг нас 25-70 нас

<sup>19</sup> Норвеги улсын 1915 оны Шүүхийн тухай хууль, 91 хэсгийг харна уу, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон

<sup>20</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбарт иш татсан (ХБНГУ-ын 1975 оны Шүүхийн Үндсэн хууль, 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон), 34-р хэсэг болон өмнө нь 19-р зүүлт тайлбарт иш татсан (1915 оны Шүүхийн тухай хууль, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон), 71-р хэсэг.

<sup>21</sup> 35-р хэсгийг харна уу, 1974 оны ХБНГУ-ын Залуусын шүүхийн тухай хууль, 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон, болон 1997 оны Хорват улсын Өсвөр настны тухай хуулийн 40-р зүйл.

<sup>22</sup> Өмнө нь 18-р зүүлт тайлбарт иш татсанг харна уу (2005 оны Хорват улсын шүүхийн тухай хууль), 133-р зүйл, болон Өмнө нь 19-р зүүлт тайлбарт иш татсан (1915 оны Норвеги улсын Шүүхийн тухай хууль, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон), 86-р хэсэг.

<sup>23</sup> Хорват, Дани болон Норвеги улсад мэргэжлийн бус шүүгчдийг 4 жилээр томилдог, харин Хорват улсад дахин томилогдох боломжтой байдаг, Өмнө нь 18-р зүүлт тайлбарт иш татсанг харна уу, 2005 оны Хорват улсын Шүүхийн тухай хууль, 132-р зүйл, Өмнө нь 19-р зүүлт тайлбарт иш татсан ((1915 оны Норвеги улсын Шүүхийн тухай хууль, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон), 66-р хэсэг, Дани улсын мэргэжлийн бус шүүгчийн болон төлөөллийн шүүгчдийн тогтолцооны талаарх мэдээллийг <http://www.domstol.dk/om/publikationer/HtmlPublikationer/Profil/Profilbrochure%20-%20UK/kap08.html>. харна уу, Өмнө нь 17-р зүүлт тайлбарт иш татсан, ХБНГУ-д мэргэжлийн бус шүүгчийн 5 жилээр томилдог, 36-р зүйл

<sup>24</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 28-р хэсэг иш татсан

<sup>25</sup> Өмнө нь 19-р зүүлт тайлбарт иш татсан (1915 оны Норвеги улсын Шүүхийн тухай хууль, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон), 14-р хэсэг

<sup>26</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбарт иш татсан, долоодугаар гарчиг

<sup>27</sup> Өмнө нь 21-р зүүлт тайлбарт иш татсан (1974 оны ХБНГУ-ын Залуусын шүүхийн тухай хууль, 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон), 35-р хэсэг

<sup>28</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 29-р хэсэгт иш татсан

- бус шүүгчтэй байдаг.<sup>29</sup> ХБНГУ-ын давж заалдах шатны шүүхэд 2-3 мэргэжлийн шүүгч, 2 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй байдаг.<sup>30</sup> Дани улсын дүүргийн шүүхэд шүүгчийн бүрэлдэхүүн нь 1 мэргэжлийн шүүгч, 2 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй байдаг, харин дээд шүүхэд 3 мэргэжлийн болон 3 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй байдаг.<sup>31</sup> Хорват улсад бүсийн шүүхэд тухайн хэргийн ангилал, ялаас хамааран мэргэжлийн болон мэргэжлийн бус шүүгчдийн харьцааг тодорхойлдог байна.<sup>32</sup> Итали улсад ялын хэмжээ их хэргүүд дээр 2 мэргэжлийн шүүгч, 6 lay judge буюу мэргэжлийн бус шүүгч оролцдог (жишээлбэл доод тал нь 24 жилийн хорих эсхүл бүх насаар нь хорих ялтай болон улсын эсрэг үйлдсэн гэмт хэрэгт).<sup>33</sup>
23. Швед зэрэг зарим улсад тухайн хэрэг дээд шатны шүүх рүү шилжих бүрт lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийн тоо цөөрдөг<sup>34</sup> (жишээлбэл давж заалдах шатны шүүх дээр 3 мэргэжлийн шүүгч, 2 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчтэй оролцдог бол Дээд шүүх дээр lay judge буюу мэргэжлийн бус шүүгч оролцдоггүй байна<sup>35</sup>).
24. Шүүх хурлын өмнө lay judge буюу мэргэжлийн бус шүүгч шүүх хуралд бэлтгэлтэй орох нь чухал байдаг хэдийн ХБНГУ зэрэг улсуудад lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийг хэргийн материалтай урьдчилж танилцахыг зөвшөөрдөггүй. Хэргийн материалтай урьдчилж танилцсан тохиолдолд хариуцагч/шүүгдэгчийн эсрэг субъектив хандлага төрөх магадлалтай. Харин Хорват болон Польш зэрэг улсуудад lay judge буюу мэргэжлийн бус шүүгч хэргийн материалтай танилцах боломж нь нээлттэй байдаг бол Дани улсад lay judge буюу мэргэжлийн бус шүүгчид хэргийн материалын нэг хувийг өгдөг байна.<sup>36</sup>
25. Шүүх хурлын мэтгэлцээний явцад мэргэжлийн болон lay judge буюу мэргэжлийн бус шүүгч нарыг ижил түвшинд авч үздэг. lay judge буюу мэргэжлийн бус шүүгч шүүх хуралдааны мэтгэлцээнд оролцохоос<sup>37</sup> гадна мэргэжлийн шүүгчийн хамт хэрэгт авагдсан нотлох баримт болон хуулийн үндэслэлд тулгуурлан шийдвэр гаргадаг.<sup>38</sup> Япон улсад 1 мэргэжлийн шүүгч хэргийн талаар асуулт асуудаг ч 1 шүүгч, 1 lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүгчдийн панелийн олонхийн саналаар шийдвэр гаргадаг.<sup>39</sup> Харин Норвеги улсад мэргэжлийн шүүгчийн бичгээр гаргасан шүүхийн шийдвэртэй lay judge буюу мэргэжлийн бус шүүгч заавал санал нэгдэж, зөвшөөрсөн байх ёстой байдаг.<sup>40</sup> Зарим улсад санал өгөх тусгай дараалалтай байдаг (жишээлбэл ХБНГУ-ад lay judge буюу мэргэжлийн бус шүүгчид түрүүлж саналаа өгдөг).<sup>41</sup>

<sup>29</sup> 1-р хэсэг, 2-р бүлэг, Финляндын Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3b, 1-р хэсэг, Швед улсын Шүүхийн процессийн хууль 1998 он.

<sup>30</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 76-р хэсэгт иш татсан

<sup>31</sup> Өмнө нь 23-р зүүлт тайлбарт иш татсан (Дани улсын мэргэжлийн бус шүүгчид болон төлөөллийн шүүгчийн тогтолцооны тойм).

<sup>32</sup> Тус гэмт хэрэгт оногдох хоригдох ял шийтгэл 10-15 жил тохиолдолд, 1 мэргэжлийн шүүгч 2 мэргэжлийн бус шүүгчтэй хуралдаанд оролцоно. 15-аас дээш жилийн хорих ялд 2 мэргэжлийн шүүгч, 4 мэргэжлийн бус шүүгч байна.

<sup>33</sup> Өмнө нь 6-р зүүлт тайлбар, 9 хуудсыг иш татсан

<sup>34</sup> Өмнө нь 5-р зүүлт тайлбар, хуудас 1036 иш татсан.

<sup>35</sup> Өмнө нь 29-р зүүлт тайлбарт иш татсан (1998 оны Швед улсын Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль) 4-р хэсэг, 3-р бүлэг

<sup>36</sup> Өмнө нь 5-р зүүлт тайлбар, хуудас 1055 иш татсан

<sup>37</sup> Өмнө нь 18-р зүүлт тайлбарт иш татсан (2005 оны Хорват улсын шүүхийн тухай хууль), 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, 7-р зүйл

<sup>38</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 30-р хэсэг иш татсан

<sup>39</sup> Өмнө нь 6-р зүүлт тайлбарт иш татсан, pp. 11-12.

<sup>40</sup> Өмнө нь 6-р зүүлт тайлбар, 12-р хуудаст иш татсан

<sup>41</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 197-р хэсэгт иш татсан

**2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаарх Монгол Улсын Шүүхийн  
иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад  
холбогдох хууль, тогтоомж**

**2.1 Холбогдох хуулиудын тойм**

26. Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн (өөрөөр lay judge буюу мэргэжлийн бус шүүгч нэрлэдэг) талаарх гол хууль бол Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль (цаашид “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хууль” гэнэ) гэж ойлгогдож байгаа ч тус хуулийн 2 дугаар заалтад Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэсэн байна.
27. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна гэж заасан байна.
28. Тус хууль нь иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралд оролцох эрх, үүрэг, тавигдах шаардлага болон сонгон шалгаруулалтын журам, татгалзан гарах талаар ерөнхий заасан байна. Мөн ажиллах нөхцөл, нөхөн олговор болон хариуцлагын талаар зохицуулалттай байна.
29. Харин Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу “Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх” гэсэн зүйлд иргэдийн төлөөлөгчийн талаар дурьдсан байна. Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шудрага ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах гэж заасан байна.
30. 2001 оны Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд<sup>42</sup> (34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт) анхан шатны шүүхийн хүнд ангилалтай хэрэг, маргаанд 3 иргэдийн төлөөлөгч оролцуулж нотлох баримтыг судлаж үнэлэх, хэрэгт санал өгөх зохицуулалттай байсан бөгөөд тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт ээдрээтэй хэрэг шүүгчийн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 2 иргэдийн төлөөлөгч оролцохоор зохицуулсан байсан. Бусад бүх хэрэг, маргаанд 1 иргэдийн төлөөлөгч оролцуулна. Мөн хуучин хуульд иргэдийн төлөөлөгч асуулт асуух (34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг), шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр өгөх эсхүл иргэдийн төлөөлөгчид санал зөрсөн тохиолдолд саналаа тус тусдаа гаргаж өгөх (34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг) зохицуулалттай байсан. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг өөрөөр зохицуулсан байна. Тус хуулийн Англи хувилбар байхгүй учир энэхүү саналд тусгагдаагүй болно. Ирээдүйд нөхцөл байдал өөрчлөгдвөл АИХЭГ нэмэлт үнэлгээ гаргаж өгөх магадлалтай. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд анхан шатны шүүх хуралд шүүгчийн бүрэлдэхүүн оролцож байгаа бол 3 хүртэлх

<sup>42</sup> 2001 оноос хойш Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд өөрчлөлт орсон бололтой, хэрэв тийм бол, хуулийн дүгнэлтэд багтахгүй. Агуулгын хувьд, дүгнэлтэд хэр их өөрчлөлт оруулах магадлалтайгаас хамаарч ирээдүйд АИХЭГ цаашид дүгнэлтэд өөрчлөлт оруулан дахин дүгнэлт гаргах магадлалтай.

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

иргэдийн төлөөлөгч шүүх хуралд оролцох боломжтой (86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэг); шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүхийн “хэргийн оролцогч”, эксперт эсхүл гэрчтэй адил оролцогч мөн (85 дугаар зүйл) гэж заасан байна. Тус хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсэгт шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг тус хуулийн 78 дугаар зүйлд заасан шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилно гэж заасан байна.

31. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлд заасан байна. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч хэргийн материалтай танилцах, тэмдэглэл хөтлөх, нотлох баримтад судлан шинжлэх ба шүүгчийн дараагаар хэргийн оролцогч, төлөөлөгч, өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэр болон экспертээс (86.2.1-3 дахь заалтууд) асуулт асуух (108.2 дахь зүйл) эрхтэй. Мөн иргэдийн төлөөлөгчид шүүх хуралд оролцож буй бусад оролцогчид болох эксперт, орчуулагч, хэлмэрч болон нарийн бичгийн даргыг (86.2.2 дахь зүйл) татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй. Шүүх хуралдаанд хэргийн нотлох баримтыг шинжлэн судласны дараа маргааны үйл баримт, “зохигчийн гэм буруугийн талаар” дүгнэлтээ гаргана (86.2.4, 86.3 болон 113 дахь зүйл заалтууд). Тус хуулийн 100 дахь зүйлийн 100.8 дахь хэсэгт иргэдийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна гэж заасан байна.
32. Шүүхийн иргэдийн төлөөлөгч хуваарилсан шүүх хуралдааныг таслахгүй байх ба “өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын” нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээнэ (86.2.5-6 дахь зүйл). Мөн хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх үүрэг хүлээдэг (86.2.7 дахь зүйл).
33. Тус хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэг болон 91.1.1 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн төлөөлөгч урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон бол хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй. Мөн хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцохгүй (91.1.2 дахь зүйл). Үүнтэй адил, иргэдийн төлөөлөгч хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал (91.1.3 дахь зүйл) эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай нөхцөл байдалтай бол (91.1.4 дэх зүйл) хэрэг хянан шийдвэрлэхэд оролцохгүй.
34. Тус хуулийн 91 дүгээр зүйлд заасан нөхцөл байдлын дагуу иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны өмнө эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол “өөрөө татгалзан гарах” үүрэг хүлээнэ (92.1 дэх зүйл). Тус хуулийн 92.2 дахь хэсэгт заасны дагуу тус хуулийн 91 дүгээр зүйлд заасан үндэслэлээр иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэх үүрэгтэй гэж заасан байна. Татгалзан гаргах тухай хүсэлт гарвал шүүх хэргийн оролцогчийн санал, түүнчлэн татгалзан

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

гаргагдаж байгаа этгээд (хүсвэл түүний) тайлбарыг сонсоно (92.3 дахь зүйл) мөн татгалзан гаргах тухай асуудлыг хүлээн авах эсэхийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хэлэлцэж, шийдвэрлэнэ (92.4 дэх зүйл).

**2.2 Холбогдох хуулиудыг харьцуулах нь**

35. Дээр дурьдсан хуулиудын заалтууд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуультай уялдаагүй хэд хэдэн зүйл байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 2 дугаар зүйлд тус хууль нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас бүрдэнэ гэсэн байтал хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт хуулийг зөвхөн иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хэрэглэхээр байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлд “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж заасан нь Үндсэн хууль өөрөө эрүү, иргэн, захиргааны шүүхийн ялгааг гаргаагүй байна.
36. Хэрэг бүрт оролцох иргэдийн төлөөлөгчийн тооны хувьд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хурлын 9 дүгээр зүйлийн 9.3 дэх хэсэгт шүүх хуралдааны хэрэгт нэг иргэдийн төлөөлөгч сонгох бөгөөд нөөцөнд 2-ыг сонгодог байна. Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлтэй нийцэхгүй байна, учир нь тус заалтад “шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд гурав хүртэл иргэдийн төлөөлөгчийг оролцуулна” гэсэн байна.
37. **Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн дотор байгаа зөрүүтэй ойлголт болон тус хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хооронд байгаа ялгаа, зөрүүтэй ойлголтуудыг арилгах ёстой. Хууль хоорондын үг хэллэгийг цэгцэлж ижил болгох хэрэгтэй, үүнийг нэг бол Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйльд өөрчлөлт оруулснаар эсхүл холбогдох хуулиудын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулах юм. Мөн тус хуулийн 12 дугаар зүйлд “тус хуулийн 3.3 дахь зүйлд (Иргэдийн төлөөлөгч оролцуулах) заасны дагуу нэг шүүх хуралдаанд нэг л иргэдийн төлөөлөгч оролцоно” гэж заасан байдаг.**
38. Тус хуулийг ерөнхийд нь дахин нэг хянах хэрэгцээ харагдаж байна, үүний зэрэгцээ тус хуулийн 2 дугаар зүйлд заасан бусад холбогдох хууль, тогтоомжийг мөн адил адил түвшинд авч үзэх ёстой. **Процессийн хувьд хэрэн хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтууд өмнөх хуулийнд байсан зохицуулалтыг хэвээр үлдээх боломжтой ч Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд үүнийг тусгах ёстой.**

**3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулалт болон шүүх бүрэлдэхүүн**

39. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулалттай холбоотой заалтууд тус хуулийн 8, 9 дүгээр зүйлд оршино. Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөл<sup>43</sup> сонгон

<sup>43</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл 5 орон тооны гишүүнтэй, үүнээс 3 гишүүнийг анхан, давж заалдах болон Улсын дээд шүүхээс нэр дэвшдэг, 1 гишүүнийг Монголын хуульчдын холбоо, 1 гишүүнийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус нэр дэвшүүлээд Монгол Улсын Ерөнхийлөгч томилно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтцэд Шүүхийн ёс зүйн хороо, Шүүхийн мэргэшлийн хороо

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

шалгаруулалтын журам боловсруулах үүрэг хүлээж байна. Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах жагсаалтыг тухайн орон нутгийн шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргах ба жагсаалт нь “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог” харгалзан гаргадаг (8.2-р зүйл) бөгөөд нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр юм (8.3-р зүйл).

40. Тус хуулийн 5 дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчид тавих шаардлагыг заасан байдаг. Үүнд насны доод хязгаар, иргэншил, орон нутгийн шүүх байрлах газарт оршин суудаг байх, ял шийтгүүлж байгаагүй байх болон сонгогдон шалгагдах үед явагдаж буй шүүх хуралдааны оролцогч биш байх. Монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог (бичгэн болон аман) байх болон сүүлийн нэг жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх ёстой.
41. Эдгээр иргэдийн төлөөлөгчид тавигдах шаардлагууд байх нь зөв ба ЕАБХАБ-ын бусад гишүүн улсын (догол мөр 18-ыг харна уу, *өмнө нь дурьдсан*) хуулиудтай давхцал их байна, тавигдах шаардлагыг нэмэхийг бодож үзэх хэрэгтэй. Мөн түүнчлэн, иргэдийн төлөөлөгчид шүүн таслах ажиллагааг харж чаддаг, ярьж чаддаг */хөгжлийн бэрхшээлгүй/* байх ёстой. Иймэрхүү зохицуулалтыг тусгахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхахгүйг анхаарч болгоомжтой байх нь чухал бөгөөд боломжтой бол, иргэний үүргээ биелүүлэх нөхцөл боломжоор хангах хэрэгтэй. Шүүх эрх мэдлийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боломжит орчин бүрдүүлж, ажилд авах болон ажилд нь байлгах бүхий л бололцоог хангахаар бодлого боловсруулахыг бодолцох ёстой.
42. Иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн шүүхийн тамгын газар нь иргэдийн төлөөлөгчийн жагсаалтад орсон нэр дэвшигчийн шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлгээ хийх бөгөөд тус хуулийн 13 дугаар зүйлийн дагуу тухайн жилд сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийн талаарх мэдээллийн санг Шүүхийн ерөнхий зөвлөлийн боловсруулсан журмын дагуу үүсгэх үүрэг хүлээдэг (8.5-р зүйл). Иргэдийн төлөөлөгчдийн нэгтгэсэн жагсаалтыг Шүүхийн ерөнхий зөвлөл баталдаг (8.6-р зүйл). Энэ асуудлын хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлд орон нутгийн шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон иргэнийг тус хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана гээд тус хуулийн 5 дугаар зүйлийг иш татдаг хэдий ч 6 дугаар зүйлийг дурьдахгүй байна (тус хуулийн 6 дугаар зүйл мөн адил тавигдах шаардлагыг заасан байна). **Тус хуулийн 8 дугаар зүйлд нэмж тусгахыг зөвлөж байна.**
43. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу орон нутгийн шүүхийн захиргааны ажилтын нь 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасан нэгтгэсэн нэрсийн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгоно. Шүүх тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасан нэрсийн жагсаалтаас долоо хоног тутам нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулна (9.2-р зүйл).

---

болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл байна. Мөн бүх шүүхийн тамгын газар, шүүхийн ерөнхий зөвлөлийн газар, нэгж багтана. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://eng.judcouncil.mn/> харна уу.

Шүүхийн ерөнхий зөвлөл бол шүүх эрх мэдлийн байгууллага мөн бөгөөд шүүхийн захиргааг хариуцдаг (Шүүхийн тухай хуулийн 6.5-р зүйл); тус зөвлөл шүүх хуралдааны танхимын зохион байгуулалт болон стандартыг хариуцдаг (Шүүхийн тухай хуулийн 8.3-р зүйл), шүүгч томилох журам батлах, шүүхийн төсөв боловсруулах (Шүүхийн тухай хуулийн 12.7, 28.4-р зүйл). Мөн тус зөвлөл шүүгчдийн тоо болон цалингийн хэмжээнд санал боловсруулдаг бөгөөд шүүх байгуулах, өөрчлөн байгуулах эсхүл татан буулгах, Ерөнхий шүүгчийн томилох болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ (Шүүхийн тухай хуулийн 6.5, 11.3, 12.4-р зүйл).

44. Тус хуулийн 9 дүгээр зүйл ойлгомжгүй, эргэлзээ төрүүлэхээр байна, учир нь 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу нэрсийн дэд жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахгүй харин 9.1 дэх хэсэгт заасны дагуу “тус хуулийн 8.6-д заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулна” гэсэн байна. Харин эсрэгээрээ нэрсийн дэд жагсаалт үүсгээд дараа нь тэрэнд тулгуурлан иргэдийн төлөөлөгчдийг сонгон шалгаруулж байвал илүү логиктой юм. **Хуулийн 9 дүгээр зүйлд үүнийг тодорхой болгож тусгах ёстой.**
45. Иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулахын тулд тус хуулийн 8 дугаар зүйлд заасан шалгуур, процесс болон стандарт дээр нэмэх ёстой. Мөн, сонгон шалгаруулалтыг хариуцдаг этгээдүүд хэрхэн иргэдийн өөр, өөр төлөөллийн оролцоог хангах талаар илүү дэлгэрэнгүй зохицуулах хэрэгтэй. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасан байна, харин **хэрхэн ялгаварлан гадуурхахаас сэргийлэх болон хэрэгжүүлэхэд хариуцсан этгээд ямар шалгуур, журмыг ашиглах талаар дэлгэрэнгүй дурьдах ёстой.**
46. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт шашин эсхүл шүтлэг, үндэстэн, эсхүл улс төрийн үзэл баримтлал зэрэг нэмэлт зүйлүүд тусгахыг зөвлөж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд хүнийг үндэс, угсаа, шашин шүтлэг, үзэл бодол эсхүл боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг. Тус хуулийн 6.2 дахь хэсгийн үг, хэллэгийг үүнтэй нийцүүлэхийг зөвлөж байна.
47. Хууль нь иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтад олон төрлийн төлөөлөл оролцох боломжоор хангасан байх ёстой. **Энэхүү жагсаалтад тухайн орон нутагт оршин суудаг өөр өөр мэргэжил, гарал үүсэл, үндэс угсаа, жендер, нас болон мэргэжлийн хүмүүс байх нь зохимжтой.** Жагсаалтыг боловсруулахад мөрдөх зарчим (демографик, газарзүйн эсхүл сонгуулийн нэрсийн жагсаалтаас санамсаргүй байдлаар түүвэрлэх), олонхийн дээд хэмжээ болон жендерийн тэнцвэртэй төлөөлөл<sup>44</sup> зэргийг тодорхойлон хуульчилж өгвөл тус дэмтэй.
48. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт шүүх хуралдааны тов зарлагдмагц (энэ нь шүүх хуралдаан бүрт байх) энэ хуулийн 9.2-т заасан дэд жагсаалтад нэр нь орсон нэг, нөөцөд хоёр иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд сугалаагаар хуваарилна гэж заасан байна. Үүнээс харахад санамсаргүй түүвэрийн аргаар сонгон шалгаруулах ажиллагаа явуулах нь тодорхой бус байх бөгөөд тус хуулийн 9.3 дахь зүйлд заасны дагуу “сугалаагаар” гэдэг нь тус хуулийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу “тохиолдлын аргаар” юугаар ялгаатай нь тодорхой биш байна.
49. **Хуулиар сонгон шалгаруулалтын процессийг илүү нарийн тодорхойлж процессийн нээлттэй болон шударга байдлыг хангах ёстой.** Сонгон шалгаруулалтын механизм тууштай болон тогтмол байх ёстой бөгөөд бүх иргэдийн төлөөлөгч ижилхэн шалгуур, журмаар сонгогдох ёстой, үүнийг

<sup>44</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 36-р хэсэгт иш татсан, мэргэжлийн бус шүүгчид нэр дэвшигчийг нийт хүн амын бүх бүлгийн хүмүүсээс оролцуулах хэрэгтэй, үүнд хүйс, нас, мэргэжил болон нийгмийн статус хамаарна. Мөн өмнө нь 19-р зүүлт тайлбарт иш татсан (Норвеги улсын 1915 оны Шүүхийн тухай хууль, 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон) Норвеги улсын сонгон шалгаруулах процесс (64-65-р хэсэг), мэргэжлийн бус шүүгчдийг 2 төрлийн сангаас сонгон шалгаруулдаг, нэг нь эрэгтэйчүүд байдаг бол нөгөөд нь эмэгтэйчүүд бүртгэлтэй байдаг байна.

хангахын тулд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд иргэдийн төлөөлөгч сонгон шалгаруулах процессийг тодорхой болгох хэрэгтэй. Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагааны механизм нь олон нийтэд сонгон шалгаруулалтын шалгуур, стандарт болон процессийн талаар мэдээллэдэг байх ёстой.

50. Мөн нэг шүүх хуралдаанд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулж байгаа нь нийтлэг биш бөгөөд бусад ЕАБХАБ-ын улсуудад байдаггүй зохицуулалт юм. Хоёр дахь хэсэгт Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хууль болон бусад холбогдох хууль хооронд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн тоо өөр өөр байгааг дурьдсан байгаа, мэргэжлийн шүүгч болон иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүний талаарх асуудлыг тус тусад нь шийдвэрлэх хэрэгтэй. Үүний хүрээнд ЕАБХАБ-ын гишүүн улс болон бусад улсуудад шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй ижил утгатай ойлголт байдаг нь lay judge буюу мэргэжлийн бус шүүгч юм (шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуулийг харахад мэргэжлийн бус шүүгчийн тухай ойлголттой хэр төстэй вэ гэдгийг мэдэх боломжгүй байна).
51. Холимог tribunal буюу холимог шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй тусгай шүүхтэй (мэргэжлийн болон мэргэжлийн бус шүүх бүрэлдэхүүнтэй шүүх эсхүл тусгай шүүх) ихэнх улсад шүүх хуралдаанд оролцох lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийн тоо нь нэгээс илүү байдаг (догол мөр 17-г харна уу *өмнө нь дурьдсан*). Харин Монгол Улсад хуулиар бол шүүх бүрэлдэхүүнд 3 мэргэжлийн шүүгч, 1 иргэдийн төлөөлөгч байхаар заасан.
52. Бусад улсад шүүх бүрэлдэхүүнд мэргэжлийн бус шүүгч нь мэргэжлийн шүүгчийн тооноос их байдаг нь жинхэнэ хяналт тавих, ил тод нээлттэй шийдвэр гаргах болон шүүх эрх мэдлийн алдаатай захиргаа удирдлагаас болж авлигад өртөхөөс сэргийлэх ач тустай гэж тайлбарладаг. Мөн мэргэжлийн бус шүүгч олон байх тусмаа мэргэжлийн шүүгч нар шүүн таслах ажиллагаанд илүү анхаарч, үр дүнтэй ажилладаг. Харин 3 мэргэжлийн шүүгчийн дунд 1 иргэдийн төлөөлөгч байснаар тухайн иргэдийн төлөөлөгч ганцаардах, хүчгүй санагдаж шүүн таслах ажиллагаанд үр дүнтэй ажиллах нөхцөлд нөлөөлөх аюултай.
53. **Иймд Монгол Улсын шийдвэр гаргагчид шүүхийн иргэдийн төлөөлөгчийн статус болон зорилгыг дахин хянаж шүүх бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн тоог нэмэх асуудлыг бодолцож үзэх хэрэгтэй.** Энэ нь иргэдийн төлөөлөгчийн статус болон чиг үүргээс нилээн хамаарах асуудал юм (илүү дэлгэрэнгүйг догол мөр 62-66-г харна уу, *хойно дурьдсан*).
54. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт нэг жил хүчинтэй байгаа нь бусад олон улстай харьцуулбал богино хугацаа юм.<sup>45</sup> Мөн бусад улстай харьцуулахад жагсаалтыг боловсруулах захиргааны болон зохион байгуулалтын ажлууд илүү ойр ойрхон хийгддэг байна. Иймд **шүүх болон нутгийн захиргааны байгууллагын ачааллыг бууруулж захиргааны чирэгдэл үүсгэхгүйн тулд иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах процессийг дахин хянаж сургалт болон бусад процессийн ажиллагаануудыг бодолцох нь зүйтэй.**
55. Тус хуулийн 9 дүгээр зүйлд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохоор сонгогдсоны дараа хэрхэхийг зохицуулсан байна. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт Шүүх хуралдаанд оролцох тухай шүүхийн мэдэгдэх хуудсыг шүүх

<sup>45</sup> Өмнө нь 18-р зүүлт тайлбарт иш татсан (ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх), 36-р хэсэг

хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнд хүргүүлж мэдэгдэнэ гэж заасан байна. Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ (9.6-р зүйл), ажил олгогч нь тус хуулийн 9.7 дахь заалтын дагуу ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ.

56. Шүүх хуралдаан болохоос ажлын таван өдрийн өмнө иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнд мэдэгдэнэ гэдэг нь ерөнхийдөө хэтэрхий бага хугацаа байна; энэ хугацааг уртасгаж, доод тал нь хэдэн долоо хоног болгох хэрэгтэй. Мөн түүнчлэн, энэ хугацаа нь нөөц иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд хамараалтай эсэх нь тодорхойгүй байна. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг дээрх шалтгааны улмаас тодорхой болгох хэрэгтэй.
57. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасан ажил олгогчид мэдэгдэх мэдэгдэл нь хачирхалтай байна, ихэвчлэн сонгогдсон иргэн өөрөө ажил олгогчдоо мэдэгдэж шүүхийн мэдэгдлийг танилцуулдаг жишиг байна. Үүний дараа шүүх ажил олгогчийг олж, холбогдох эсэхээ өөрөө шийддэг учир нь шүүхэд хэтэрхий их ачаалал өгдөг байна. Энэхүү заалтыг дахин хянаж үзээд ажиллагаанд оролцож буй бүх талуудад асуудал багатайгаар шийдвэрлэх шийдлийг олох хэрэгтэй.
58. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д заасны дагуу ажил олгогч нь иргэдийн төлөөлөгчид “асуудал үүсгэлгүй” чөлөө олгох зохицуулалт нь хязгаарлагдмал байна, үүнийг илүү гүнзгийрүүлж цар хүрээг нь өргөн болгох хэрэгтэй. Энэхүү заалтыг тодорхой болгож иргэдийн төлөөлөгчөөр шалгарсан иргэний ажил нь хэвээр хадгалагдах баталгааг хангах ёстой.

#### **4. Иргэдийн төлөөлөгчийн эрх**

59. Иргэдийн төлөөлөгчийн эрхтэй холбоотой зохицуулалт хуулийн 3 дугаар зүйлд заасан байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д иргэдийн төлөөлөгч нь шүүгчийн дангаар шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцохгүй гэж заасан нь иргэдийн төлөөлөгч зөвхөн шүүх бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд л оролцох эрхтэй байна. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1-д заасны дагуу иргэдийн төлөөлөгч нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд оролцох эрхтэй гэж заасан байна.
60. Үүнд “оролцох” гэдэг үг тодорхой бус байна. Хуулийн 3.3.1-д шүүх хуралдааны хэрэг “хянан шийдвэрлэхэд оролцох” гэсэн бол 12.1-д хэрэг, маргааныг шинжлэн, судлах болон шийдвэрлэхэд оролцоно гэж заасан байна. Мөн Шүүхийн тухай хуулийн 8.4 дэх заалтад иргэдийн төлөөлөгчийн оролцоотойгоор шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэнэ гэж заасан байна.
61. Үүний зэрэгцээ, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд иргэдийн төлөөлөгчийн чиг үүргийг тодорхойлсон байдаг ч шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгч асуулт асууж болохыг болон шүүх хуралдааны эцэст саналаа танилцуулж болохыг бараг дурдаагүй байна. Мөн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны мэтгэлцээнд оролцох, шүүхийн шийдвэр гаргах процессд оролцох эсэхийг тодорхой заагаагүй байна. Орчуулгын алдаа биш бол иргэдийн төлөөлөгчийн статус нь шүүгчтэй гэхээсээ илүү шүүх хуралдааны оролцогч болох хэргийн оролцогч, гэрч эсхүл экспертийн чиг үүрэгтэй ойрхон байна.

62. Иймд иргэдийн төлөөлөгч нь бусад улсад хэрэгждэг lay judge буюу мэргэжлийн бус шүүгч гэсэн ойлголтоос өөр болохыг тогтоолоо (догол мөр 23-ыг харна уу *өмнө нь дурьдсан*), lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийг мэргэжлийн шүүгчтэй адилтгаж үздэг байна. Тиймээс иргэдийн төлөөлөгч нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг болохоос биш хэргийн бусад оролцогч болох хэргийн оролцогч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, гуравдагч этгээд болон экспертээс юугаараа ялгаатай вэ гэсэн асуулт урган гарч ирлээ. Мөн хуульд тусгасан энэхүү хандлага нь эрүүгийн болон бусад шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн талаарх олон улсын ойлголттой нийцэхгүй бөгөөд олон улсад иргэд шүүх хуралдаанд оролцсоноор шүүхийн шийдвэрт тодорхой чиг үүрэгтэй оролцдог.
63. Үүний хүрээнд, тус хуулийн 1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилтийг “шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах” гэж заасан байна. Үүний адил Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд шүүхийн “ил тод, шудрага болон нийтийн хяналт”-ыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцуулна гэж заасан байна. Иргэдийн төлөөлөгч зөвхөн шүүх хуралдаанд оролцоод байхгүй давхар камержуулсан буюу онлайн шүүх хуралдаанд оролцоод байвал дээрх зорилго хэрэгжих боломжтой. **Хэдийгээр улсууд lay judge буюу мэргэжлийн бус шүүгчийн эсхүл төлөөлөгчдийн шүүхийн тогтолцоог улсдаа нэвтрүүлэх үүрэг хүлээдэггүй ч шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог үр дүнтэй болгоход хэрэг, маргааны мэтгэлцээн болон шийдвэр гаргах процессд бодитоор нөлөөлж, оролцох юм; ингэснээр шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн санал, дүгнэлтийг шийдвэр гаргах ажиллагаандаа тусгаж хүлээн авна гэсэн үг юм.**
64. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хууль болон бусад дээр дурьдсан хуулиудад нэр томъёоны хувьд тодорхой бус байдал тулгарч байгаа нь Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор дээрх хуулиудад иргэдийн төлөөлөгчийг “шүүх бүрэлдэхүүн”-нд хамаатуулж байсныг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосон (тус хуулийн 3.3.1, 3.4, 9.3, 12.1, болон 12.2 дахь заалтууд). Үүний улмаас иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүний нэг хэсэг гэсэн ойлголтыг тодорхойлж байсан бүх заалтыг хүчингүй болгосон мөртлөө шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн байр суурь, оролцоонд нэмэлт тайлбар хийгээгүй байна.
65. Гэсэн хэдий ч иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хяналтын чухал чиг үүргийг гүйцэтгэх боломжтой ч хуульд нарийвчлан тусгах ёстой байна. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэг хянан шийдвэрлэх процессийн хуульд тусгахдаа хэргийн оролцогч болох талууд, итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч болон экспертүүдэд таалагдах биш шүүгчид таалагдах байдлаар тусгах нь зүйтэй.
66. **Тиймээс иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо мэтгэлцээнд болон шүүхийн шийдвэрт оролцох эсэхийг тодорхой заах шаардлагатай. Энэхүү нэмэлт, өөрчлөлт батлагдсан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (аль хэзээний тусгагдаагүй нөхцөлд) болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд мөн адил тусгагдах ёстой. Шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог тодорхой зааж өгснөөр хуульд заасан ил тод мэтгэлцэх зарчим хэрэгжинэ.**
67. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-д заасан иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвхөн шүүх хуралдаанд оролцох эсэхийг биш маш нарийвчлалтай тодорхойлсон

байх ёстой Generally, Article 3.3 should outline the rights of citizen representatives in greater detail. Хуулийн заалтад иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хэргийн материалтай танилцах болох эсэх (зарим улсад lay judges буюу мэргэжлийн бус шүүгчиддээ хэргийн материалтай танилцах эрх олгодоггүй, ялангуяа, эрүүгийн хэрэг дээр учир нь шүүгдэгчийн эсрэг субъектив хандлага үүсгэхгүйн тулд (догол мөр 22-ыг харна уу *өмнө дурьдсан*). 2001 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 261 дүгээр зүйлийн 261.3 болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлд зааснаар иргэдийн төлөөлөгч хэргийн материал болон нотлох баримттай танилцах эрхтэй гэж заасан боловч энэ нь зөвхөн шүүх хуралдааны явцад танилцуулсан хэргийн материал, нотлох баримт бололтой; энэ асуудлын хүрээнд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйл болон холбогдох процессийн хуулиуд илүү тодорхой, дэлгэрэнгүй болгох хэрэгтэй.

68. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д зааснаар иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэхээ батлан тангараглана. Хуулийн 3.5-д Шүүхийн ерөнхий зөвлөл тангаргийн журмыг батална гэсэн байна. **Тангаргийг тодорхой байлгах үүднээс хуульд тусгахыг бодолцох хэрэгтэй.**<sup>46</sup>
69. Тус хуулийн бусад заалтууд ч мөн адил иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар заасан байна. Хуулийн 7 дугаар зүйлд жишээлбэл Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглосон байгаа нь иргэдийн төлөөлөгч хяналтын чиг үүргээ биелүүлэхэд тус болж, албан тушаалыг нь бэхжүүлж өгч байна. Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал чухал хэдий ч 7 дугаар зүйл заасан “аливаа хэлбэрээр” гэдэг хэтэрхий ерөнхий байна. Үүнийг хэргийн оролцогч талууд шүүх бүрэлдэхүүнд (иргэдийн төлөөлөгчид мөн адил) нөлөөлөх гэж шүүх хуралдаан болохоос өмнө сөрөг нэхэмжлэл эсхүл тайлбар бичгээр өгөхийг ч хамаатуулах магадлалтай байна. Шүүгчид мөн адил иргэдийн төлөөлөгч хуулийг дагаж, мөрдүүлэхийн тулд нөлөөлөх гэж оролдох магадлалтай. **Шүүн таслах ажиллагааны бусад үед хууль бус харилцаа үүсэх эсхүл зүй бус нөлөөлөл үзүүлж иргэдийн төлөөлөгчийн болон шүүхийн процессийн нэр хүндийг унагах магадлалтай тул эдгээрийг хуулийн 7 дугаар зүйлийг шинэчлэн найруулгад тусган шинэчлэх хэрэгтэй.**
70. Тус хуулийн 7.2 дугаар зүйлд 7.1-д заасан нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.2-т заасан нөлөөллийн мэдүүлэг бөглөнө. Харин тухайн нөлөөллийн мэдүүлгийн үр дагаварын болон процессийн үр дүнг дурьдаагүй байна. **Таамаглахад, эдгээр төрлийн асуудлын процесс нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлтэй адилхан байх гэж бодож байна гэвч эдгээр хууль, журмыг дагаж мөрдөхгүй байгаа процессийн асуудлуудыг тодорхой болгох хэрэгтэй.**

<sup>46</sup> Тангараг өргөдөг төрөл олон улсад өөр өөр байдаг бөгөөд ихэвчлэн дэлгэрэнгүй, тодорхой болон тус хуулийн 3.4-д заасан процессээс илүү дэлгэрэнгүй байдаг. Франц улсад, жишээлбэл, эрүүгийн хэрэгт оролцож буй төлөөлөгчдийн шүүхийн төлөөлөгч дараах тангаргийг өргөх ёстой, үүнд: “... эсрэг энэхүү хэрэгт би хамаг анхаарлаа хандуулан дүн шинжилгээ хийхээ андгайлж байна, шүүгдэгчийн, нэхэмжлэгч болон хохирогч талын алиныхан ч ашиг сонирхлыг хуурахгүй, хэргийг үнэн зөв тодорхойлох хүртэл хэнтэй ч ярилцахгүй байж, хэрэгт үзэн ядалт эсхүл өс хонзонгоор бус, шударга болон хараат бус байдлаар шийдвэр гаргаж хүний, шүүх хуралдаан дууссан ч мэтгэлцээний нууцыг хадгалаж байна”

Төлөөлөгчдийн шүүхийн төлөөлөгч бүрийг ерөнхийлөгч дуудан асуухад тэд “Би амлаж байна” гэж хариулдаг.

Их Британид төлөөлөгчдийн шүүхийн төлөөлөгч дараах тангаргийг өргөдөг “ Би амлаж байна [Бурханы, Аллах, Вахегүрү, Гита, г.м нэрийн өмнөөс] шүүгдэгчийг шударгаар сорьж, асууж, нотлох баримтад суурилсан жинхэнэ шийдвэр гаргана.”

71. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт тус хуулийн 21.1-ийг зөрчсөн аливаа этгээд хариуцлага хүлээн гэсэн байна. Дээр зөвлөсний дагуу Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 7.1 дэх заалтын үгийг өөрчлөхтэй адил иргэдийн төлөөлөгчид нөлөөлснөөр шүүх хуралдааны шударга байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
72. Хууль тогтоогчид болон шийдвэр гаргагчид иргэдийн төлөөлөгчийн эрхийг хамгаалсан, аюулгүй байдлын хангасан нэмэлт заалтууд тусгах нь зүйтэй. Тус хуульд оруулсан 2013 оны нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болсон 7.3-д зааснаар иргэдийн төлөөлөгчийн аюулгүй байдлыг тухайн шүүхийн тамгын газар хангана. Ихэнх улсад энэ мэт хуулиар хамгаалсан хамгаалалт байдаг байна, тиймээс энэ заалтыг хассан явдал нь ойлгомжгүй бөгөөд гайхшрал төрүүлж байна. Иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэж буй чиг үүрэг нь аюул заналд өртөх магадлал өндөр бөгөөд зарим тохиолдолд бүр доромжлол эсхүл биеийн хүчирхийлэлд өртөх магадлалтай. **Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 7.3 дахь зүйлийг өөр хуульд тусгасан байх боломжтой ч Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд тусгахыг илүүд үзэх хэрэгтэй, эсхүл тусгагдсан хуулийн заалтыг энэ хуульд заас ёстой.** Мөн түүнчлэн, өөрийн цагийг нийтэд үйлчлэхэд зориулж буй иргэдийг төр маргаангүй хамгаалах үүрэгтэй.
73. Хамаарал бүхий шийдвэр гаргагчид шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн халдашгүй байдлыг тогтоох зэргээр хамгаалах арга хэмжээг гүнзгийрүүлэх боломжтой юм. **Шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгч шүүн таслах ажиллагааны халдашгүй байдалтай байж шүүх эрх мэдэлд саад, бэрхшээлгүй оролцох боломжоор хангаж чадвал үр дүнтэй.**<sup>47</sup> Иргэдийн төлөөлөгчийн эдлэх халдашгүй байдлын цар хүрээг шийдвэр гаргагчид шийдэх бөгөөд иргэдийн төлөөлөгчийн чиг үүрэг шүүгчтэй адилхан болох тусам халдашгүй байдлын заалт хүчтэй байна.
74. Иргэдийн төлөөлөгчид санамсаргүй түүврээр нэг жилийн хугацаатай сонгогддог бөгөөд мэргэжлийн бус шүүгчийн статустай боллоо гэхэд, **иргэдийн төлөөлөгчид өөрсдийн чиг үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, албан үүрэгтэй бэлэн байх нь чухал.** Тус хуулийн 11.3-д заасны дагуу шүүхийн тамгын газар тухайн жилд сонгогдон шалгарсан иргэдийн төлөөлөгчдөд хамтарсан сургалт зохион байгуулдаг. Эдгээр сургалтуудыг бүх иргэдийн төлөөлөгч оролцох боломжтой үеийг сонгон зохион байгуулах нь чухал. Хуулийн 11.4-д иргэдийн төлөөлөгч ерөнхий боловсролын мэдлэгтэй байх бөгөөд энэ нь иргэдийн төлөөлөгчдөд өгдөг тусгай сургалтыг орлохгүй. Хуульд иргэдийн төлөөлөгч заавал суух ёстой сургалтад суухыг шаардаггүй. **Хуульд ийм шаардлага оруулж бүх иргэдийн төлөөлөгч ижил түвшний мэдлэгтэй болох нь хэрэгтэй байх.**

## **5. Иргэдийн төлөөлөгчийн үүрэг, татгалзан гаргах болон хариуцлага хүлээлгэх**

### **5.1 Иргэдийн төлөөлөгчийн хүлээх үүрэг**

75. Тус хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу иргэдийн төлөөлөгчид хориглосон хэдэн зүйл байдаг. Иргэдийн төлөөлөгчид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх

<sup>47</sup> Өмнө нь 18-р зүйлийг иш татсан (2005 оны Хорватын Шүүхийн тухай хууль), 8-р зүйлд шүүгч болон мэргэжлийн бус шүүгч “шүүх хуралдааны мэтгэлцээнд үзэл бодлоо илэрхийлсний төлөө эсхүл санал өгсний төлөө хариуцлага хүлээхгүй”

хуралдааныг орхиж болохгүй. Тус хуулийн 9.5 болон 9.8-д иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохгүй болсон шалтгаанаа урьдчилж мэдэгдэх бөгөөд эрүүл мэндийн шалтгааны улмаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсонгоо эмчийн бичгээр, ажлын айлчлалаар явсан бол ажил олгогчийн бичгээр, хүүхэд эсхүл настай хүн харах шаардлагатай бол өрхийн эмнэлэг эсхүл орон нутгийн Засаг даргаас болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай бол бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

76. **Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэг нь маш тодорхой бус байх тул өөр хуулийн дагуу хүндэтгэн үзэх шалтгаан юу болох нь тодорхой бус байна. Энэ асуудлыг тодорхой болгохыг зөвлөж байна.** Түүнчлэн, тус хуулийн 9.8-д заасан шалтгаануудаас илүү яаралтай, чухал асуудлууд болох гэнэтийн эрүүл мэндийн асуудал тулгарах эсхүл хойшлуулшгүй ажил зэрэг нь тодорхой бус байна. Шүүх хуралдаанд оролцохгүй татгалзан гарах шалтгааныг жагсааж дурьдаж байснаас асуудлын чухалчлал, хүнд байдал зэргийг тодорхойлдог шалгуур үзүүлэлт тусгах хэрэгтэй.<sup>48</sup> Тус шүүх хуралдаанаас татгалзан гарах хүсэлтийг хүлээн авсан шүүх шалтгааныг хуульд заасны дагуу үнэлэх юм. Мөн тодорхой мэргэжилтэй хүмүүс иргэдийн төлөөлөгчөөр ажиллахаас татгалзах зохицуулалтыг нэмэх хэрэгтэй.<sup>49</sup>
77. Тус хуулийн 4.1-д заасны дагуу иргэдийн төлөөлөгч хэргийн нотлох баримтын талаар хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзахыг хориглосон байна. Иргэдийн төлөөлөгчид төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах (таамаглавал шүүх хуралдаанаас олж мэдсэн мэдээлэл байх), хэлвлэл мэдээллийн хэрэгсэлд хэргийн талаар мэдээлэл өгөх, зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал, хэлэлцсэн асуудлыг задруулахыг хориглосон байна. Шүүхийн ерөнхий зөвлөл тус хуулийн 4.1-д заасан зүйлийн хэрэгжилтийг хянаж “зөрчил гаргасан иргэдийн төлөөлөгчийн эрхийг хасна” (4.2-р зүйл).
78. **Энэ асуудлын хүрээнд “зөрчил гаргасан иргэдийн төлөөлөгчийн сонгогдох эрхийг хасах” гэдэг тодорхойгүй байна, (орчуулгын алдаа байх магадлалтай) тодорхой болгох хэрэгтэй.** Иргэдийн төлөөлөгч сонгогдох эрхээ хасуулна гэдэг тодорхой бус байна учир нь зөрчил гаргах хүртэл тэд аль хэзээний сонгогдсон бөгөөд шүүх хуралд оролцож байсан болно (мөн дэд жагсаалтаас сонгогдон шалгарсан). Магадгүй хуулийн 4.2 дахь хэсэг иргэдийн төлөөлөгчийн эрхийг хасна гэсэн үг байх, тийм байсан ч энэ асуудлыг тодруулах хэрэгтэй.
79. Жишээлбэл Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлтэй ижил тусгал мэт зохицуулалттай байна (өөрөөр бичсэн байгаа хэдий ч утга ижил байна, эсхүл буруу орчуулгын улмаас), үүнд “иргэдийн төлөөлөгч хувь хүний, байгууллагын эсхүл төрийн нууцыг задруулахгүй” болон шүүх хуралдааныг тасалж болохгүй. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд бусад хүлээн үүргийг дурьдаагүй байна. **Тиймээс бүх хамаарал бүхий хуулиуд иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг адилхан үг, хэллэгээр эсхүл хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтыг тусган харилцан, хамаарлыг тодорхой болгох хэрэгтэй.**

<sup>48</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 54-р хэсэгт иш татсан, үүнд мэргэжлийн бус шүүгчийн хяналтаас гадуурх асуудлыг болон түүнээс шаардаж болохгүй чиг үүргийг тусгасан байна.

<sup>49</sup> Өмнө нь 17-р зүүлт тайлбар, 35-р хэсэгт иш татсан, Үүнд, парламентийн гишүүд болон тодорхой ангаахын мэргэжлийн хүмүүсийг мэргэжлийн бус шүүгчээр ажиллахаас татгалзах боломжоор хангадаг.

80. Иргэдийн төлөөлөгчийн эрхийг хасах талаар сонсгол явуулах эсэх нь тодорхой бус байх эсхүл эрхээ хасуулсан иргэдийн төлөөлөгч эрхээ сэргээлгэхээр гомдол гаргаж болох эсэх тодорхой бус байна. **Эдгээр зүйлийг тодорхой болгоод хуулиудад тусгах шаардлагатай.**

*5.2 Иргэдийн төлөөлөгчийн татгалзан гаргах шалтгаан болон процесс*

81. Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн тухай хууль иргэдийн төлөөлөгчдэд нөлөөлөх оролдлогыг хориглосон боловч (7.1 дэх зүйл), иргэдийн төлөөлөгчийн оролцох шүүх хуралдаантай холбогдолтой эсхүл гаднаас /шүүхийн оролцогч бус/ нөлөөлөх оролдлогыг зохицуулаагүй байна. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд иргэдийн төлөөлөгчдөд зориулсан нөхцөл байдлын жагсаалт тусгасан бөгөөд уг заалтад иргэдийн төлөөлөгч мэдсэн даруйдаа авах арга хэмжээ, шүүх хуралдаанд байгаа тохиолдолд хэрхэхийг зохицуулсан байна (92.1-р зүйл). Мөн хуулийн 91.1 болон 91.3 дэх заалтад тухайн иргэдийн төлөөлөгч тус хэрэг дээр өмнө нь хэргийн оролцогчоор, гуравдагч этгээдээр, шүүхийн нарийн бичгийн даргаар, иргэдийн төлөөлөгчөөр, гэрчээр, орчуулагчаар эсхүл хэлмэлчээр оролцож байсан бол тус шүүх хуралдаанд оролцохыг хориглоно гэж тусгасан байна. Мөн иргэдийн төлөөлөгчид тус хэргийн оролцогчтой, бусад оролцогчтой эсхүл шүүх бүрэлдэхүүний шүүгчтэй холбоотой, танил, хамаатан бол татгалзан гарах үүрэгтэй.
82. Дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч өөрөө, өөрийн санаачлагаар “татгалзан гарах” үүрэгтэй (тухайн нөхцөл байдлыг илрүүлсэн хугацаанаас эхлэнэ) (92-р зүйл). Хэргийн оролцогчид, тэдний хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч эсхүл гуравдагч этгээд мөн хуулийн 91 дүгээр зүйлийн дагуу мөн адил татгалзан гаргах хүсэлт тавьж болно. Холбогдох шүүгч тус асуудлын талаар хоёр тал хоёулангаас нь асууж тодруулаад (татгалзан гаргах хүсэлт гаргасан хүн болон иргэдийн төлөөлөгч) хангах эсхүл хангахгүй байх талаар шийдвэр гаргана (92.4-р зүйл).
83. Иргэдийн төлөөлөгчөөс татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй хүмүүсийн жагсаалтыг мөн хуулийн 92.2-д заасан байх ба хүсэлт гаргаж болох хүмүүсийн жагсаалтад иргэдийн төлөөлөгч бас байж болох юм байна. Шүүх хуралдаан 1 иргэдийн төлөөлөгчтэй байлаа гэж бодоход тухайн иргэдийн төлөөлөгч өөрөө өөрийгөө татгалзан гарах хүсэлт өгөх ойлголт юм. Иргэдийн төлөөлөгчийн чиг үүрэг бол хяналт тавих чиг үүрэгтэй юм, тиймээс үүнийг тодорхой болгож, засч залруулах шаардлагатай.
84. Мөн хуулийн 92.5-8 хүртэлх заалтуудад шүүгчийн эсрэг, шүүх бүрэлдэхүүний эсрэг, эксперт, орчуулагч хэлмэрч, шүүхийн нарийн бичгийн дарга, ерөнхий шүүгч эсхүл нэг шүүхийн эсрэг гомдолыг аль шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдэх талаар тодорхой заасан байгаа хэдийн иргэдийн төлөөлөгчийн эсрэг гомдолд хэн шийдвэр гаргах нь дурьдагдаагүй байна. Иргэдийн төлөөлөгч шүүгчийн статустай хэр ойрхон, ижилхэн байна гэдэг ойлголтоос шалтгаалах зүйл юм (энэ асуудлын хувьд шүүх бүрэлдэхүүнд байгаа шүүгчид шийдвэрлэнэ (92.5-р зүйл), эсхүл иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд бусад оролцогч, эксперт, орчуулагч, шүүхийн нарийн бичгийн дарга болон дээр дурьдсан (энэ асуудлын хувьд шүүх бүрэлдэхүүн эсхүл тухайн хэрэг дээр ажилладаг шүүгч (92.7-р зүйл)) оролцогчид мэт ойлгогддог. **Ямар ч тохиолдолд, Иргэний хэргийн шүүхэд**

**хянан шийдвэрлэх тухай хуульд нарийн тодорхой тусгагдах хэрэгтэй бөгөөд  
бусад хуулиудад иш татах хэрэгтэй.**

85. Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх тухай хуульд шүүгчийг эрүүгийн хэрэгт оролцуулахгүй байх хэд хэдэн шалтгаан заасан байдаг, жишээлбэл тухайн шүүгч өөрөө хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, хуулийн албан ёсны төлөөлөгч зэрэг байвал тухайн хэргээс татгалзан гарна. Өөр татгалзан гарах шалтгаан гэвэл өмнө нь тус хэргийн эртний үед захиргааны ажилтан, мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч, эксперт, гуравдагч этгээд, гэрч эсхүл шүүхийн нарийн бичгийн дарга байсан бол эсхүл хувийн ашиг сонирхлын зөрчилтэй бол.
86. Шүүн таслах ажиллагааны шудрага, ил тод байдлын хувьд иргэдийн төлөөлөгч татгалзан гарах шалтгаанаа мэддэг байх ба холбогдох хуулиудад тусгах ёстой. Мөн процессийн зүйл заалтуудыг тусгаж нөхцөл байдлыг илрүүлсэн тохиолдолд хэрхэн болон мэдсээр байж эс үйлдэхүй бол ямар хариуцлага хүлээх талаар тодорхой тусгах ёстой. Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх туайх хуулийн шинэчилсэн найруулгад зүйл, заалт нэмэх эсхүл зохицуулагдсан хуулиудаас иш татах ёстой. Тус хуульд иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан судалгаа, хэн шийдвэр гаргах талаар тодорхой заах ёстой.
87. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан шалгуур Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хуулийн дагуу байх ёстой учир тус зүйл заалтад заасан зарим зүйл нь тус хуулийн 5 болон 6 дугаар зүйлд заасан тавигдах шалгуур болон сонгон шалгаруулалтын хориглосон заалтаас болж хэрэгжих үндэслэлгүй юм. Үүнд аливаа нэгэн шүүх хуралдаанд хэргийн оролцогч хүн иргэдийн төлөөлөгч байх шалгуур хангахгүй бөгөөд өмнөх шүүх хуралдаанд оролцогчоор оролцсон байх үндэслэлгүй юм. Мөн түүнчлэн, 6 дугаар зүйлд шүүхийн ажилтныг сонгон шалгаруулахыг хориглосон байдаг тул шүүхийн нарийн бичгийн даргыг өмнөх шүүх хуралдаанд оролцсон гэх үндэслэлээр татгалзан гаргах (шүүхийн нарийн бичгийн дарга угаасаа шүүхийн ажилтан байсан учир). Татгалзан гаргах бусад шалтгаан Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн хамааралтай зүйл заалтад тусгагдсан байх ёстой.
88. Иймэрхүү зүйл заалт Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийг орлох ёстой бөгөөд шүүх хуралдааны дундуур иргэдийн төлөөлөгчөөс татгалзан гаргах үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар тус тус зохицуулагдана гэдэг нь тодорхой бус байна. Одоогийн байгаагаар, 10 дугаар зүйл иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах хангалттай шалтгаан заагаагүй байх ба шүүх хуралдааны дундуур иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах тухай заасан байна. Харин шүүх хуралдаан эхлэхээс өмнө татгалзан гаргах талаар зохицуулалт алга. Дээр дурьдсаны дагуу 10 дугаар зүйлд татгалзан гаргах бүх шалтгааныг заагаагүй бөгөөд процесс, хэн хянан шийдвэрлэх эсэх нь тодорхой бус байна.

### **5.3 Зөрчлийн хариуцлага**

89. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцохоос хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан иргэдэд хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Тус хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцохоор 16 дугаар зүйлд заасан байна.

90. Энэхүү заалт дээрх аль хуулиар ямар нөхцөл байдал/ааш зан гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар маш бүрэг бөгөөд ерөнхий байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийн 9.8-д хуулийг аливаа нэгэн үйлдэл гаргавал зөрчсөнд тооцно гэсэн тодорхой заалт алга. Жишээлбэл тус хуулийн 4.1-д заасан зөрчил нь иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах шалтгаан болж байгаа ч хариуцлагын зүйл алга. Ийм нөхцөл байдлаас үүдээд иргэдийн төлөөлөгчид ямар нөхцөл байдал ямар хариуцлага хүлээлгэх талаар мэдэхэд бэрх байна.
91. Мөн түүнчлэн тус хууль нь иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг зохицуулах зорилготой бөгөөд тус хуулийн 16 дугаар зүйлд иргэн эсхүл аж ахуйн нэгж гэж заасан нь тодорхойгүй байна.
92. **Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд хариуцлагын зүйл заалтыг нэмэх ёстой ба аль хариуцлагын арга хэмжээ нь Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцох талаар тодорхой заах хэрэгтэй.** Ингэснээр, тус хууль нь иргэдийн төлөөлөгч болон шүүх аль алинд нь ойлгомжтой хууль болно.

## **6. Эцсийн дүгнэлт**

93. ЕАБХАБ-ын гишүүн улсууд дагаж мөрдөх эрх, үүрэг нь “нээлттэй процессийн үр дүнд шууд болон шууд бус байдлаар иргэдийн хүсэл зоригыг илэрхийлж байдаг” (Moscow Document of 1991, par 18.1).<sup>50</sup> Хүний эрх, суурь эрх чөлөөтэй холбоотой хууль зүйн актуудыг нарийн хэлэлцэж, хуулийг сайжруулах зөвлөлдөх уулзалт хийж, олон нийт болон хүний эрхийн байгууллагуудыг оролцуулан боловсруулах ёстой байдаг, энэ хуулийн хувьд мөн адил хүний эрх, суурь эрх чөлөөг хөндөж байгуу тул нэн шаардлагатай юм. Нийтийн хэлэлцүүлэг, нээлттэй мэтгэлцээн талуудын ойлголтыг нэмэгдүүлж хуулийг батлахад итгэл үнэмшил өгдөг. Монгол Улсын төрийн байгууллага энэхүү хуулийг батлагдах хүртэл хэлэлцүүлэг зохион байгуулж сонирхсон талууд болон шүүх, иргэд, нутгийн удирдлага зэрэг байгууллагуудын оролцоог хангаж байх ёстой.

*[ДУУСАВ]*

<sup>50</sup> Дараах линкээс авч болно <<http://www.osce.org/fr/odihr/elections/14310>>.

**ХАВСРАЛТ:**

2012 оны 5 дугаар сарын 22-ны  
өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль  
тогтоомж**

2.1.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Шүүхийн тухай[2], Шүүхийн захиргааны тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[3], Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

[1] Монгол Улсын Үндсэн хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

[2] Шүүхийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

[3] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ,ТҮҮНД ТАВИХ  
ШААРДЛАГА**

**3 дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх**

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар анхан шатны шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан /цаашид “хэрэг, маргаан” гэх/-ыг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

3.2.Шүүхийн иргэдийн төлөөлөгч /цаашид “иргэдийн төлөөлөгч” гэх/ шүүгчийн дангаар шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцохгүй.

3.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.3.1.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ~~шүүх бүрэлдэхүүнд~~ оролцох;

/Энэ заалтын шүүх бүрэлдэхүүнд гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

3.3.2.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.4.~~Шүүх бүрэлдэхүүнд орсон~~ иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэхээ батлан тангараглана.

/Энэ хэсгийн шүүх бүрэлдэхүүнд орсон гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

3.5.Энэ хуулийн 3.4-т заасан тангаргийн журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

**4 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

4.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

4.1.1.шүүх хуралдааныг орхин явах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;

4.1.2.шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;

4.1.3.хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;

4.1.4.хэргийн талаар нотлох баримт цуглуулах;

4.1.5.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

4.1.6.хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон хэргийн талаар мэдээлэл өгөх;

4.1.7.зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал, хэлэлцсэн асуудлыг задруулах.

4.2.Энэ хуулийн 4.1 дэх хэсэгт заасан заалтын хэрэгжилтэд Шүүхийн ерөнхий зөвлөл хяналт тавьж, зөрчсөн этгээдийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хасна.

**5 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчид тавих шаардлага**

5.1.Иргэдийн төлөөлөгч нь дараах шаардлага хангасан байна:

5.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх;

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

5.1.2. тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;

5.1.3. ял шийтгүүлж байгаагүй;

5.1.4. сонгогдон шалгарах үедээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч бус байх;

*/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

5.1.5. монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог байх;

5.1.6. сүүлийн нэг жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх.

**6 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдоход хориглох зүйл**

6.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, шүүхийн ажилтан, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, тухайн орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч, онцгой байдлын албан хаагч, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулахыг хориглоно.

*/Энэ хэсэгт 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

6.2. Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

**7 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал**

7.1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.2-т заасан нөлөөллийн мэдүүлэг бөглөнө.

~~7.3. Иргэдийн төлөөлөгчийн аюулгүй байдлыг тухайн шүүхийн тамгын газар хангана.~~

*/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

7.4. Энэ хуулийн 9.1-д заасны дагуу сонгон шалгаруулсан иргэдийн төлөөлөгчийн нэрсийг шүүгч, шүүхийн ажилтан шүүх хуралдаанаас өмнө задруулахыг хориглоно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

**8 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт**

8.1. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах журам, иргэдийн төлөөлөгчийг сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөөг тус тус батална.

***Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал***

8.2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасны дагуу гаргасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт нэг жил хүчинтэй байна.

8.4.Энэ хуулийн 8.3-т заасан хугацаа дуусахаас гурван сарын өмнө шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэх бэлтгэл ажлыг хийнэ.

8.5.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон иргэнийг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.6.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтыг хуралдаанаараа батална.

8.7.Шүүхийн ерөнхий зөвлөл нь иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаар судалгаа, дүн шинжилгээ, статистик мэдээг тогтмол гаргана.

**9 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах**

9.1.Энэ хуулийн 8.6-д заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

9.2.Шүүх энэ хуулийн 8.6-д заасан нэрсийн жагсаалтаас долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулна.

9.3.Шүүх хуралдааны тов зарлагдмагц энэ хуулийн 9.2-т заасан дэд жагсаалтад нэр нь орсон ~~шүүх бүрэлдэхүүнд өрөх~~ нэг, нөөцөд хоёр иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд сугалаагаар хуваарилна.

/Энэ хэсгийн шүүх бүрэлдэхүүнд орох гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

9.4.Шүүх хуралдаанд оролцох тухай шүүхийн мэдэгдэх хуудсыг шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнд хүргүүлж мэдэгдэнэ.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 9.8-д заасан хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газарт нэн даруй мэдэгдэнэ.

9.6.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.

9.7.Энэ хуулийн 9.6-д заасан ажил олгогч нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ.

9.8.Хуульд заасны дагуу татгалзан гараагүй бол дор дурдсан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнийг шүүх хуралдаанд оролцохоос зайлсхийсэн гэж үзэж түүнд энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ:

**Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
ЕАБХАБ/АИХЭГ-ын өгсөн Санал**

9.8.1.эмнэлгийн магадлалаар баталгаажсан эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон;

9.8.2.ажил олгогчийн баталгаажуулсан албан томилолттой байсан;

9.8.3.бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бөгөөд энэ талаар хорооны Засаг даргын тодорхойлолттой бол;

9.8.4.хүндэтгэн үзэх бусад шалтгаантай байсан.

**10 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах**

10.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө татгалзан гарах үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус тогтооно.

*/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**11 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг мэдээллээр хангах**

11.1.Шүүхийн тамгын газар нь иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд оролцох үед эдлэх эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгнө.

11.2.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчид зориулсан гарын авлага боловсруулж хүрэлцээтэй хэмжээгээр хэвлэн шүүхэд түгээх бөгөөд тухайн шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийг уул гарын авлагаар хангана.

11.3.Тухайн жилд сонгогдон шалгарсан иргэдийн төлөөлөгчид зориулсан нэгдсэн сургалтыг тухайн шүүхийн тамгын газраас зохион байгуулна.

11.4.Иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ**

**12 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцох**

*/Энэ зүйлийн гарчигийн шүүх бүрэлдэхүүнд гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/*

12.1.Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна.

*/Энэ хэсгийн шүүх бүрэлдэхүүнд гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/*

12.2.Энэ хуулийн 9.3 дахь хэсэгт заасан шүүх бүрэлдэхүүнд орсон иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол нөөцөд байгаа иргэдийн төлөөлөгчдөөс мөн хэсэгт заасны дагуу нэг иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оруулна.

*/Энэ хэсгийн шүүх бүрэлдэхүүнд гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/*

12.3.Нөөцөд байгаа иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцох боловч энэ хуулийн 3.3-т заасан бүрэн эрхийг энэ хуулийн 12.2-т зааснаас бусад тохиолдолд хэрэгжүүлэхгүй.

**ТАВДУГААР БҮЛЭГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, ХӨЛС**

**13 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн талаарх бүртгэл мэдээлэл**

13.1.Шүүхийн тамгын газар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан журмын дагуу тухайн жилийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт бүхий мэдээллийн сан бүрдүүлнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан сангийн мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэлтэй нэгтгэж архивт бүртгэнэ.

**14 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах**

14.1.Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн цагийг хэмнэх, зардал гаргуулахгүй байх зохистой арга хэмжээ авна.

14.2.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах стандартыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

14.3.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хөрөнгийг шүүхийн тамгын газарт олгоно.

**15 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох**

15.1.Иргэдийн төлөөлөгчийн хөлсийг шүүхийн төсвөөс олгоно.

15.2.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

**16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**ДОЛДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

17.1.Энэ хуулийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**  
**ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**